



ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ

2021 оны 12 дугаар сарын 10-ны өдөр

Дугаар ____

Дархан хот

Энэхүү санамж бичгийг нэг талаас Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэргэдэх Удирдлагын академи /цаашид "УА" гэх/, түүнийг төлөөлж УА-ийн захирал Д.Сүрэнчимэг, нөгөө талаас Дархан-Уул аймгийн Засаг дарга /цаашид "Аймаг", хамтад нь "Талууд" гэх/ Б.Азжаргал нар үйл ажиллагааны зорилго, зорилтод үндэслэн харилцан тохиролцож, хамтран ажиллахаар байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Гэрээний зорилго нь Талууд хамтран Аймгийн төрийн албаны шинэтгэлийг боловсронгуй болгох, сургалт, судалгаа, нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа хэрэгжүүлэх, эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийн хамтын ажиллагаа, түншлэлийг өргөжүүлэх, Аймгийн төрийн болон төрийн бус байгууллагын удирдлага, албан хаагчдад сургалт зохион байгуулах, хамтарсан судалгааны төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж зөвлөх үйлчилгээ үзүүлэх чиглэлийн хамтын ажиллагааг өргөжүүлэхэд оршино.
- 1.2. Талуудын хамтын ажиллагаа нь харилцан ашигтай, ашиг сонирхлыг хүндэтгэх, хэрэгцээнд нийцсэн байх зэрэг зарчимд тулгуурлаж, үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Боловсролын тухай хууль болон холбогдох бусад хууль эрх зүйн актыг удирдлага болгоно.

Хоёр. Талуудын хамтын ажиллагааны хүрээ

- 2.1 Талууд хамтран Аймгийн төрийн албаны шинэтгэлийг гүнзгийрүүлж, төрийн албаны шинэтгэлийн сургалт, судалгаа, зөвлөх үйлчилгээний сайн туршлагыг бий болгосон түшиц аймаг болгоход дэмжлэг үзүүлэн хамтран ажиллана.
- 2.2 Эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийн хамтын ажиллагаа, түншлэлийг өргөжүүлэх, төсөл, хөтөлбөр боловсруулж хамтран ажиллана.
- 2.3 Аймгийн төрийн захиргааны болон боловсролын байгууллагын удирдах ажилтныг чадавхжуулах тусгайлсан хөтөлбөр хэрэгжүүлэх, сургалтууд зохион байгуулах, судалгааны төсөл хэрэгжүүлнэ.
- 2.4 Хамтын ажиллагаанд хамаарал бүхий ажлаар аль нэг талын зохион байгуулж байгаа үйл ажиллагаанд талуудын төлөөллийг оролцуулна.

- 2.5 Талуудын зохион байгуулж буй маркетингийн болон олон нийтийн арга хэмжээнд хамтран оролцоно.
- 2.6 Хамтын үйл ажиллагаатай холбогдох мэдээллийг талууд өөрсдийн цахим хуудсанд байршуулж тогтмол шинэчилнэ.

Гурав. Хамтын ажиллагаанд талуудын хүлээх үүрэг

- 3.1 Талууд хамтын ажиллагаагаа хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа арга хэмжээ зохион байгуулахдаа урьдчилан харилцан мэдээлэл өгөх, хамтран оролцох зарчмыг баримтална.
- 3.2 Талууд хамтын ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах мөнгөн хөрөнгийн хариуцлага харилцан аль нэг талынхаа өмнө хүлээхгүй бөгөөд өөрсдийн боломжид тулгуурлан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
- 3.3 Талууд санамж бичгийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган хагас жил тутамд хамтын ажиллагааны талаар уулзалт, ярилцлага зохион байгуулж, ажлаа дүгнэж удирдлагадаа танилцуулж байна.

Дөрөв. Бусад

- 4.1 Энэхүү санамж бичиг нь гарын үсэг зурснаас хойш гурван жилийн хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөнө.
- 4.2 Аймгийн ЗДТГ, УА-ийн удирдлагын зүгээс энэхүү санамж бичгийг хэрэгжүүлэхэд бүх талын дэмжлэг туслалцааг үзүүлж ажиллана.

---000---

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, УДИРДЛАГЫН АКАДЕМИЙН ЗАХИРЛЫН ХООРОНД
БАЙГУУЛСАН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧГИЙН ХҮРЭЭНД УДИРДЛАГЫН
АКАДЕМИД СУРАЛЦСАН АЛБАН ХААГЧДЫН НЭРС**

№	Овог, нэр	Албан тушаал	Суралцсан мэргэшил	он	Мөнгөн дүн
1	А.Сувд-Эрдэнэ	АЗДТГ-ын ТЗУХ-ийн ахлах мэргэжилтэн	Төрийн захиргааны магистрын зэрэг олгох сургалт	2022-2023	1.000.000
2	Ц.Нямаа	АЗДТГ-ын ТЗУХ-ийн мэргэжилтэн	Төрийн захиргааны магистрын зэрэг олгох сургалт	2022-2023	1.000.000
3	Я.Цэнд-Очир	АЗДТГ-ын ЦШ-ын офицер	Төрийн захиргааны магистрын зэрэг олгох сургалт	2022-2023	1.000.000